**ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2019 оны 04 сарын 03 өдөр　　　　Дугаар А/16　　　　Улаанбаатар хот

Мөнгөн урамшуулал олгох
журам батлах тухай

Монгол улсын Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолыг үндэслэн ТУШААХ нь:

1. Төвийн эрүүл мэндийн ажилтнуудын ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэн мөнгөн урамшуулал олгох журам”-ыг 1 дүгээр, эрүүл мэндийн ажилтанд мөнгөн урамшуулал олгох үнэлгээний хуудсыг 2 дугаар хавсралтаар тус тус батлсугай.

2. Журмыг нийт ажилтнуудаар судлуулан, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, ажиллахыг ажил дүгнэх байнгын комиссын дарга, гишүүд, албадын дарга, тасгийн эрхлэгч нарт тус тус үүрэг даалгасугай.

3. Үнэлгээний дагуу төвийн ажилтнуудад мөнгөн урамшууллыг улирал тутам олгохыг Ахлах нягтлан бодогч /З.Ууганцэцэг/-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа төлөвлөлт, хүний нөөц, статистикийн албаны дарга /Б.Амгаланбаяр/-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан төвийн захирлын 2015 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/15 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ　　　　Н.ЦОГБАДРАХ

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн захирлын 2019 оны 04 дүгээр сарын 03 - ны өдрийн А/16 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

# ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТАНД МӨНГӨН УРАМШУУЛАЛ ОЛГОХ ЖУРАМ

## Нэг. Нийтлэг үндэслэл

**Зорилго:** Эрүүл мэндийн ажилтны ажлын байрны тодорхойлолтод тусгасан ажлын үр дүн, гүйцэтгэл, ёс зүйн хэм хэмжээг харгалзан мөнгөн урамшуулал олгох, гүйцэтгэлийг бодитой үнэлэх нэгдсэн аргачлалаар хангах харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.1. Төвийн Эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг нь үнэлэн дүгнэх, мөнгөн урамшуулал олгохтой холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Хуульд өөрөөр заагаагүй бол улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил, үүргээ хангалттай гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй албан хаагчид олгоно.

1.3. Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна.

1.4. Албаны дарга, тасгийн эрхлэгч нар хариуцан ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтанг сар бүр холбогдох шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэнэ.

1.5. Тасгийн эрхлэгчийн ажлын гүйцэтгэлийг албаны дарга нар, албаны даргын ажлын гүйцэтгэлийг захирал үнэлнэ.

1.6. Алба, тасгаас ирүүлсэн үнэлгээний дүнг удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн, эрүүл мэндийн ажилтанд мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг гаргаж, захирлын тушаалаар батална.

1.7. Ажилтанд нэмэгдэл, мөнгөн урамшуулал олгохдоо Монгол улсын Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Засгийн газрын тогтоол, Эрүүл мэндийн сайдын тушаал гэх мэт, бусад эрх зүйн баримтыг мөрдлөг болгоно.

## Хоёр. Мөнгөн урамшуулал олгоход баримтлах шалгуур үзүүлэлт, тооцох аргачлал

2.1. Эрүүл мэндийн ажилтанд мөнгөн урамшуулал олгохдоо энэхүү журмын 2.4-т заасан шалгуур үзүүлэлтийг баримтлан ажлын үр дүн, гүйцэтгэлийг дүгнэж, жилийн төсөвт уг урамшуулалд зориулан батлагдсан хөрөнгийн дүнд багтаан энэхүү журмын 2.5, 3.3-д заасан шийдвэрийг үндэслэн олгоно.

2.2 Ажлын үр дүн, чанар, ёс зүйн хэм хэмжээ, гүйцэтгэлээр олгох нэмэгдэл, мөнгөн урамшуулалыг захирлын тушаалаар баталгаажуулна.

2.3 Мэргэжлийн онцлогийг харгалзан тогтоосон шалгуур үзүүлэлтийг аргачлалын дагуу дүгнэнэ.

2.3.1.Мөнгөн урамшуулал олгохтой холбогдуулан Төвийн эрүүл мэндийн ажилтнуудыг ажил мэргэжил, албан тушаалаар нь 2 бүлэгт ангилна. Үүнд:

1. Албаны дарга, тасгийн эрхлэгч, үндсэн мэргэжлийн мэргэжилтнүүд үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлийг үнэлэхэд нийтлэг болон тусгай шалгуур (2.4 А.Б) үзүүлэлтээр

2. Бусад ажилтан (ахлах нягтлан бодогч, тооцооны нягтлан бодогч, эдийн засагч, хуулийн зөвлөх, архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтан, төлөвлөлт, хүний нөөц, сургалт, хяналт үнэлгээ хариуцсан мэргэжилтэн, хангамж үйлчилгээний ажилтан, автомеханик, амьтан маллагч, нярав, жолооч, слесарь, цахилгаанчин-мужаан, бэлдмэлчин, угаагч, үйлчлэгч)-ууд үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлийг үнэлэхэд нийтлэг болон тусгай шалгуур (2.4 А.В) үзүүлэлтээр дүгнэнэ.

2.4. Мөнгөн урамшуулал олгоход дараах шалгуур үзүүлэлт, аргачлалыг баримтална:

| № | Үндсэн шалгуурыг тодорхойлох тусгай үзүүлэлт | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хувь | Дүгнэх аргачлал, хэм хэмжээ |
|---|---|---|---|---|
| **А. Эрүүл мэндийн ажилтанд тавигдах нийтлэг шалгуур үзүүлэлт** | | | | |
| ***Нэг. Үйлчилгээний чанар*** | | | | |
| 1.1 | Ёс зүйн хэм хэмжээ, харьцаа хандлага байдал | Ёс зүй, харьцаа хандлагын зөрчил гаргаагүй байх | 0-10 | Ёс зүй, харьцаа хандлагатай холбоотой бичгээр ирсэн гомдол, санал, ёс зүйн салбар хорооны хурлын дүгнэлт |
| ***Хоёр. Ажлын ачаалал, хариуцлага, ажлын гүйцэтгэл*** | | | | |
| 2.1 | Ажлын цаг ашиглалт | Ажлын цагийн бүртгэлийн дүн | 0-10 | Цахим бүртгэл, удирдлагын багийн гишүүдийн явцын үзлэг, тасаг, албаны дарга эрхлэгчийн тойрон үзлэгийн бүртгэлийг үндэслэх |
| 2.2 | Ажлын ачаалал | Ажлын ачаалал ,үүрэг даалгаврын биелэлтийн байдал | 0-5 | Ажлын ачаалал /Нэмэлтээр хийсэн ажил буюу хавсарч ажилласан байдал/, өгсөн үүрэг даалгаврын биелэлт |
| 2.3 | Хариуцсан өмч хөрөнгийн ашиглалт | Өмч хөрөнгийн ашиглалтын байдал | 0-5 | Хариуцсан өмч, хөрөнгө, багаж тоног төхөөрөмжийн алдагдаагүй байх |
| 2.4 | Төлөвлөгөөт ажлын гүйцэтгэл | Албан хэргийн бүртгэл, хөтлөлт, тайланг хугацаанд нь гаргасан байх | 0-10 | Төлөвлөгөөт ажлын гүйцэтгэл, тайланг хугацаандаа гаргасан байх,<br><br>АШБМаягтын тоо, мэдээ<br><br>Шинжилгээний хариуг хугацаанд нь мэдээлсэн эсэх |
| ***Гурав. Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд оруулсан хувь*** | | | | |
| 3.1 | Үргүй зардлыг багасгах талаар тодорхой санал санаачилга гарган ажилласан байдал | Эдийн засгийн хэмнэлт гаргаж, Тодорхой санал санаачлага гаргасан байдал | 0-5 | Үргүй зардлыг багасгасан тооцоо, судалгаа үндэслэх, хувь хүн санаачлан хэрэгжүүлсэн ажил үйлчилгээ, гаргасан зардал |
| 3.2 | Ажлын идэвхи, олон нийтийн арга хэмжээнд оролцсон байдал | Олон нийтийн үйл ажиллагаанд оролцсон идэвхи, санаачлага, ирцийн байдал | 0-5 | Ажлын идэвхи, олон нийтийн арга хэмжээнд оролцсон байдал, хамт олны хурал зөвлөгөөнд зарчмын оновчтой санал дэвшүүлж шийдвэрлүүлсэн, олон нийтийн арга хэмжээнд оролцож, хамт олноо тэргүүлэн идэвхижүүлсэн, амжилт гаргасан байх |
| **Нийтлэг шалгуурын нийт оноо 50** | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Б. Эмнэлгийн мэргэжилтний тусгай шалгуур үзүүлэлт** | | | | |
| ***Нэг. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар*** | | | | |
| 1.1 | Эмчилгээ, үйлчилгээний стандартыг мөрдөж байгаа байдал | Стандартын мөрдөлт | 0-10 | Эмчилгээ, оношилгооны түгээмэл үйлдлийн стандарт, удирдамж, заавар, технологийн мөрдөлт |
| 1.2 | Халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж байгаа байдал | Халдвар хамгааллын дэглэмийн мөрдөлт | 0-10 | Халдвар хамгаалал биоаюулгүй ажиллагааны дэглэмийн заавар зөрчөөгүй байх |
| 1.3 | Эмчилгээ, үйлчилгээний талаар гаргасан гомдол | Оношилгоо, эмчилгээ, үйлчилгээ, бусад ажлын дутагдлын тохиолдол гараагүй байх | 0-10 | Чанарын баг, удирдлагын зөвлөлийн хурлаар анхааруулга, сануулга, арга хэмжээ авагдсан байдал, оношилгоо, эмчилгээ үйлчилгээний доголдол гаргасан байдал нь батлагдсан байх |
| 1.4 | ЗӨСТ болон бусад, эрүүл мэндийн байгууллага болон ард иргэдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн | ЗӨСТ болон бусад, эрүүл мэндийн байгууллага болон ард иргэдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн байх | 0-10 | ЗӨСТ болон бусад, эрүүл мэндийн байгууллага болон ард иргэдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн байх |
| 1.5 | Ажлын байрны тодорхойлолтод заасан ажлын гүйцэтгэл, чанар | Ажлын гүйцэтгэлийн байдал | 0-10 | Ажлын байрны тодорхойлолтод заагдсан хэрэгжүүлэх үйл ажиллагааны биелэлт |
| **Эмнэлгийн мэргэжилтний тусгай шалгуур үзүүлэлтийн оноо 50** | | | | |
| **В. Эрүүл мэндийн бусад ажилтаны тусгай шалгуур үзүүлэлт** | | | | |
| ***Нэг. Хариуцсан ажлын чанар*** | | | | |
| 1.1 | Стандарт мөрдөж байгаа байдал | Стандарт болон бусад эрх зүйн баримт бичгийн байдал | 0-10 | Мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой стандартыг зөрчөөгүй байх |
| 1.2 | Халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж байгаа байдал | Халдвар хамгааллын дэглэмийн мөрдөлт | 0-10 | Халдвар хамгаалал биоаюулгүй ажиллагааны дэглэмийн заавар зөрчөөгүй байх |
| 1.3 | Ажлын байрны тодорхойлолтод заасан ажлын гүйцэтгэл, чанар | Ажлын байрны тодорхойлолтын үндсэн зорилтын гүйцэтгэлийн байдал | 0-10 | Ажлын байрны тодорхойлолтод заагдсан хэрэгжүүлэх үйл ажиллагааны биелэлт |
| 1.4 | Аюулгүй ажиллагааны мөрдөлт, ажлын байрны бэлэн байдал | Ажлын байрны аюулгүй ажиллагааг мөрдөж ажлын байрны бэлэн байдлыг ханган ажилласан байдал | 0-10 | Ажлын байрны аюулгүй ажиллагааг мөрдөж ажлын байрны бэлэн байдлыг ханган ажилласан байх |
| 1.5 | Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт | Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелүүлсэн байдал | 0-10 | Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт |
| **Эрүүл мэндийн бусад ажилтаны тусгай шалгуур үзүүлэлтийн оноо 50** | | | | |

## Гурав. Үнэлгээний аргачлал

**3.1 Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн хувийг тооцохдоо:**

3.1.1. Ажилтны тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, ажлын байрны тодорхойлолтод заасан гол үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь, шалгуур үзүүлэлтийн хувийг тус бүрд нь дор дурдсан томъёогоор гаргана.

**ЗБ = Г/ Т х100**
**Зорилтын биелэлт= ЗБ**
**Гүйцэтгэл – Г**
**Төлөвлөгөө - Т**

Жишээ нь: Төвийн дэвшүүлсэн 1 дүгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд 50 асуудал төлөвлөсний 48 нь биелсэн байна гэж үзвэл: ЗБ=/ 48:50/х100=96 хувь байна. Зорилт биелэлтийн оноог гаргахдаа 0,05 гэсэн тогтмол тоогоор үржүүлнэ. Жишээ нь: ЗБ=48:50х0,05=4,8: Зорилгын биелэлт нь 96 хувь буюу 4,8 оноо байна.

**3.2. Шалгуур үзүүлэлтийн хувийг тооцохдоо:**

3.2.1 Дундаж оноог гаргахдаа шалгуур үзүүлэлтийн нийлбэрийг шалгуурын тоонд хуваaж дундаж оноог гаргана.
3.2.2. Тоогоор илэрхийлж үнэлэх боломжгүй зорилт арга хэмжээний үнэлгээний оноог тодорхойлохдоо тухайн зорилт арга хэмжээний биелэлтийн хувийг 0,05-аар үржүүлж тодорхойлно.

**3.3. Биелэлтийн хувийг тодорхойлохдоо дараах зарчмыг баримтална.**

3.3.1 Тухайн заалтаар тавьсан зорилтдоо бүрэн хүрч, энэ талаар холбогдох шийдвэр, үр дүн гарч, тогтворжсон бол 100 хувь,

3.3.2 Тухайн заалтаар тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч холбогдох арга хэмжээ авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлж байгаа бол 90.0 хувь /80-100 хувь/,
3.3.3 Тухайн заалтаар тавьсан зорилтдоо хүрэхийн тулд өөрсдөөсөө хамаарах бүх шийдвэр гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, шийдвэр гаргагч дээд байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа бол гүйцэтгэлийн байдлыг харгалзан 70.0 хувь /60,0-80.0 хувь/,
3.3.4 Бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн бол хийгдэж буй ажлын түвшинг харгалзан 50.0 хувь /40.0-60.0 хувь/,
3.3.5 Тухайн заалтад тусгагдсан асуудлыг шийдвэрлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа бол хийгдэж буй ажлын түвшинг харгалзан 30.0 хувь /20.0-40.0 хувь/,
3.3.6 Арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон арга хэмжээг авч эхэлж байгаа бол ажлын түвшинг харгалзан 10.0 хувь /0-20.0 хувь,
3.3.7 Ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол 0 үнэлгээ өгнө.

4.1. Ажилтнуудын ажлын үр дүнг “А”, “В” гэж үнэлж, улирал бүр дүгнэнэ.

4.2. Ажлын үр дүн, гүйцэтгэлээр олгох нэмэгдэл хөлс олгох шалгуурын дагуу үнэлгээг улирал бүр хийнэ. Ажлын үр дүн, гүйцэтгэлийн үнэлгээнээс хамааран доорхи хувь хэмжээгээр сар бүр тооцож улирал тутамд олгоно.

| № | Бүх шалгуурын биелэлтийн хувь | Ажлын үр дүнгийн үнэлгээ | Албан тушаалын үндсэн цалингаас урамшил тооцох хувь (сард) |
|---|---|---|---|
| 1. | 90-100 | A | 11-13.3 |
| 2. | 71-89 | B | 7-10 |
| 3. | 70 доош | хангалтгүй | - |

4.3. Дараах тохиолдлуудад ажлын үр дүн, гүйцэтгэлээр олгох нэмэгдэл хөлс урамшуулал ажилтанд олгохгүй.

- Үр дүнгийн шалгуурын биелэлт 70 ба түүнээс доош хувьтай үнэлэгдсэн,
- Ёс зүйн салбар хорооны болон халдвараас сэргийлэх хяналтын багийн хурлаар тухайн улиралд асуудал нь хэлцэгдэн арга хэмжээ тооцогдсон
- Эрүүл мэндийн байгууллагын захирлын тушаалаар сахилгын шийтгэл ногдуулсан тухайн улирлын хугацаанд
- Туршилтын хугацаатай, гэрээгээр ажиллаж байгаа, ээлжийн амралтын хугацаатай сард
- Сард ажиллавал зохих хоногийн 75%-иас доошгүй хувьд ажиллаагүй бол

4.4. Албадын дарга, тасгийн эрхлэгч нар хариуцаж буй алба тасгийнхаа ажилтны ажлын үр дүн гүйцэтгэлийн үнэлгээг сар бүр хийж, улирлаар нь нэгтгэн дүнг хамт олны хурлаар хэлэлцүүлэн, тухайн улирлын дараа сарын 05-ны дотор чанар хяналт үнэлгээ дотоод аудитын албанд ирүүлнэ.

4.5. Чанар хяналт үнэлгээ дотоод аудитын алба нь үр дүн гүйцэтгэлийн үнэлгээг хийж нэгтгэн эцсийн дүнг удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

4.6. Үнэлгээний дүнг үндэслэн, ажилтнуудад мөнгөн урамшуулал олгох шийдвэрийн дагуу тушаал гаргаж тухайн улирлын дараа сарын 10-ны дотор багтаан санхүү эдийн засаг, хангамж үйлчилгээний албанд өгнө.

4.7. Мөнгөн урамшлыг тухайн улирлын дараа сарын 15-ны дотор олгоно.

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн
захирлын 2019 оны 04 дугаар сарын 03 - ны
өдрийн А/16 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТАНД МӨНГӨН УРАМШУУЛАЛ
ОЛГОХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

| № | Үндсэн шалгуурыг тодорхойлох тусгай үзүүлэлт | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хэрэгжилт | Үнэлгээ | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Өөрийн | Алба, тасаг | ЧХҮДАА |
| **А. Эрүүл мэндийн ажилтанд тавигдах нийтлэг шалгуур үзүүлэлт** | | | | | | |
| ***Нэг. Үйлчилгээний чанар*** | | | | | | |
| 1.1 | Ёс зүйн хэм хэмжээ, харьцаа хандлага байдал | Ёс зүй, харьцаа хандлагын зөрчил гаргаагүй байх | | | | |
| ***Хоёр. Ажлын ачаалал, хариуцлага, ажлын гүйцэтгэл*** | | | | | | |
| 2.1 | Ажлын цаг ашиглалт | Ажлын цагийн бүртгэлийн дүн | | | | |
| 2.2 | Ажлын ачаалал | Ажлын ачаалал ,үүрэг даалгаврын биелэлтийн байдал | | | | |
| 2.3 | Хариуцсан өмч хөрөнгийн ашиглалт | Өмч хөрөнгийн ашиглалтын байдал | | | | |
| 2.4 | Төлөвлөгөөт ажлын гүйцэтгэл | Албан хэргийн бүртгэл, хөтлөлт, тайланг хугацаанд нь гаргасан байх | | | | |
| ***Гурав. Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд оруулсан хувь*** | | | | | | |
| 3.1 | Үргүй зардлыг багасгах талаар тодорхой санал санаачилга гарган ажилласан байдал | Эдийн засгийн хэмнэлт гаргаж, Тодорхой санал санаачлага гаргасан байдал | | | | |
| 3.2 | Ажлынидэвхи, олоннийтийнаргахэмжээндоролцсонбайдал | Олон нийтийн үйл ажиллагаанд оролцсон идэвхи, санаачлага, ирцийн байдал | | | | |
| **Нийтлэг шалгуурын нийт оноо** | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **Б.Эмнэлгийн мэргэжилтнийтусгай шалгуур үзүүлэлт** | | | | | | |
| ***Нэг. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар*** | | | | | | |
| 1.1 | Эмчилгээ, үйлчилгээний стандартыг мөрдөж байгаа байдал | Стандартын мөрдөлт | | | | |
| 1.2 | Халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж байгаа байдал | Халдвар хамгааллын дэглэмийн мөрдөлт | | | | |
| 1.3 | Эмчилгээ, үйлчилгээний талаар гаргасан гомдол | Оношилгоо, эмчилгээ, үйлчилгээ, бусад ажлын дутагдлын тохиолдол гараагүй байх | | | | |
| 1.4 | ЗӨСТ болон бусад, эрүүл мэндийн байгууллага болон ард иргэдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн | ЗӨСТ болон бусад, эрүүл мэндийн байгууллага болон ард иргэдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн байх | | | | |
| 1.5 | Ажлын байрны тодорхойлолтод заасан ажлын гүйцэтгэл, чанар | Ажлын гүйцэтгэлийн байдал | | | | |
| **Эмнэлгийн мэргэжилтнийтусгай шалгуур үзүүлэлтийн оноо** | | | | | | |
| **В.Эрүүл мэндийн бусад ажилтаны тусгай шалгуур үзүүлэлт** | | | | | | |
| ***Нэг. Хариуцсан ажлын чанар*** | | | | | | |
| 1.1 | Стандарт мөрдөж байгаа байдал | Стандарт болон бусад эрх зүйн баримт бичгийн байдал | | | | |
| 1.2 | Халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж байгаа байдал | Халдвар хамгааллын дэглэмийн мөрдөлт | | | | |
| 1.3 | Ажлын байрны тодорхойлолтод заасан ажлын гүйцэтгэл, чанар | Ажлын байрны тодорхойлолтын үндсэн зорилтын гүйцэтгэлийн байдал | | | | |
| 1.4 | Аюулгүй ажиллагааны мөрдөлт, ажлын байрны бэлэн байдал | Ажлын байрны аюулгүй ажиллагааг мөрдөж ажлын байрны бэлэн байдлыг ханган ажилласан байдал | | | | |
| 1.5 | Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт | Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелүүлсэн байдал | | | | |
| **Эрүүл мэндийн бусад ажилтаны тусгай шалгуур үзүүлэлтийн оноо** | | | | | | |